



**МОНГОЛ УЛС
ДОТООДЫН ЦЭРГИЙН КОМАНДЛАГЧИЙН
ТУШААЛ**

2021 оны 02 дугаар сарын
18-ны өдөр

Дугаар **A/04**

Улаанбаатар
хот

**Дүрэм шинэчлэн батлах
тухай**

Дотоодын цэргийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалтыг үндэслэн ТУШААХ НЬ:

1. “Дотоодын цэргийн алба хаагчийн ёс зүйн дүрэм”-ийг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2. Дүрмийг алба хаагчдаар судлуулж, мөрдүүлэх, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Дотоодын цэргийн штабын дарга /хурандаа С.Ганбат/-д үүрэг болгосугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан Дотоодын цэргийн командлагчийн “Дүрэм батлах тухай” 2018 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн A/16 дугаар тушаалыг хүчингүйд тооцсугай.

КОМАНДЛАГЧ, ЦАГДААГИЙН
ХУРАНДАА

Ж.БОЛД

ХУУЛБАР ҮНЭН
Дотоодын цэргийн штабын дарга,
хурандаа

С.Ганбат

ДОТООДЫН ЦЭРГИЙН АЛБА ХААГЧИЙН ЁС ЗҮЙН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Дотоодын цэргийн алба хаагч, ажилтан бүр хуулиар тогтоосон бусад чиг үүргээ хэрэгжүүлэх үйл ажиллагаандаа баримтлах ёс зүйн хэм хэмжээг хэвшүүлэх, ёс зүйн зөрчлөөс сэргийлэх, дотоодын цэргийн байгууллага, алба хаагчийн нэр төрийг хамгаалахад энэ дүрмийн зорилго оршино.

1.2. Дотоодын цэргийн алба хаагч, ажилтан нь үйл ажиллагаандаа Дотоодын цэргийн тухай хуулийн 3.1 дэх хэсэгт заасан зарчмыг баримтална.

1.3. Энэ дүрэмд заасан дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

1.3.1. "Ёс зүйн хэм хэмжээ"-дотоодын цэргийн алба хаагчаас өргөсөн тангарагтаа үнэнч байж, хуульд заасан чиг үүргээ биелүүлэх явцад үйл ажиллагаандаа дагаж мөрдөхдөө эрхэмлэвэл зохих зан үйлийн нийлбэр цогцыг;

1.3.2. "Ёс зүйн зөрчил" - хууль, тогтоомж болон энэ дүрмээр тогтоосон хэм хэмжээг зөрчсөн үйлдэл, эс үйлдлийг;

1.3.3. "Шалгагч" - Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам /Код-112/-ын дагуу ёс зүйн хэм хэмжээ зөрчигдсөн үйлдлийг шалгахаар томилогдсон албан тушаалтныг;

1.3.4. "Ноцтой зөрчил" - Дотоодын цэргийн тухай хууль, Дотоодын цэргийн үйл ажиллагааны журамд тус бүр тодорхойлон заасан, Дотоодын цэргийн байгууллагын нэр хүндийг гутаах, эд хөрөнгийн хохирол учруулах зэрэг эрх ашиг, сонирхолд нөлөөлөхүйц сөрөг үр дагаврыг санаатай болон санаандгүй буй болгосон, энэ дүрэмд заасан зөрчлийн шийтгэлгүйд тооцох хугацаа өнгөрөөгүй үед хоёр буюу түүнээс дээш зөрчсөн үйлдэл, эс үйлдлийг;

1.4. Энэхүү дүрэм нь Дотоодын цэргийн офицер, ахлагч, гэрээт болон хугацаат цэргийн алба хаагч нарт үйлчилнэ.

1.5. Энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэж буй болон гадаад, дотоодын сургууль, дамжаанд суралцагчид, хурал, семинар сургалт, уулзалтад оролцож буй алба хаагчдад нэгэн адил хамаарна.

Хоёр. Алба хаагч, ажилтны ёс зүйн хэм хэмжээ

2.1. Хууль дээдлэх:

2.1.1. өргөсөн тангарагтаа үнэнч байж, Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомж, Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар батлагдсан "Цэргийн нийтлэг дүрэм"-ийг чанд мөрдөж, дээд шатны албан тушаалтны хуульд нийцсэн шийдвэрийг ёсчлон биелүүлж, захирах, захирагдах ёсны зарчмыг баримтлан ажиллах;

2.1.2. нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртахууны хэм хэмжээ болон дотоодын цэргийн үйл ажиллагааны журмыг сахин мөрдөх;

2.1.3. албан үүргээ гүйцэтгэх явцдаа төрийн байгууллага, хувь хүний хуулиар хамгаалагдсан нууцыг задруулах, хувийн болон бусдын ашиг сонирхлын төлөө ашиглахгүй байх, албан ёсны шийдвэр гараагүй аливаа асуудлын талаар байр суурь илэрхийлэхгүй байх, зөвшөөрөлгүй мэдээ, мэдээлэл тараахгүй байх.

2.2. Хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх:

2.2.1. хүнийг үндэс угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол, эрүүл мэндийн байдал, бэлгийн чиг хандлагаар нь ялгаварлан гадуурхахгүй байх;

2.2.2. дотоодын цэргийн байгууллагын үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ бусдын эрхэнд хууль бусаар халдах, чирэгдүүлэх, дарамтлах, хүнд суртал гаргахгүй байх;

2.2.3. албан тушаалын бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ иргэн, хамтран ажиллаж байгаа алба хаагчтай адил тэгш, хүлээцтэй, хүндэтгэлтэй харилцаж, тэдний нэр төр, алдар хүнд, хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хүндэтгэх.

2.3. Шударгаар ажиллаж, амьдрах:

2.3.1. хууль тогтоомж зөрчсөн, албан тушаалын байдлаа урвуулсан, хэтрүүлэн ашигласан болон ёс зүйн хэм хэмжээ зөрчсөн аливаа үйлдэлтэй эвлэрэхгүй байх, хамтран ажиллаж байгаа алба хаагч, хамгаалуулагч байгууллагад энэ талаар хууль ёсны шаардлага тавих;

2.3.2. бусад байгууллага, хамтран ажиллаж байгаа алба хаагчийн албаны ажилд хүндэтгэлтэй хандаж, үйл ажиллагаанд нь хөндлөнгөөс нөлөөлөхгүй, бусдад зуучлахгүй байх, өөрт хамааралгүй хэрэг маргаанд оролцохгүй байх;

2.3.3. авилга, хээл хахууль авах, өгөх, зуучлахгүй байх;

2.3.4. Төр, цэргийн болон байгууллага, хувь хүний нууцыг чанд хадгалж, албан үүргээ гүйцэтгэх явцдаа олж авсан мэдээ, мэдээллийг Дотоодын цэргийн байгууллага, алба хаагчийн нэр төрд харшилж болох болон өөрийн санхүү, эдийн засгийн аливаа хэлцэл, хөрөнгө оруулалт, эдийн засгийн бусад ашиг сонирхлоо хэрэгжүүлэх үйл ажиллагаанд ашиглахгүй байх, зуучлахгүй байх;

2.3.5. албан тушаал, хуулиар олгогдсон эрх мэдлээ хувийн зорилгод ашиглахгүй байх, бусдад давуу байдал бий болгох, үгсэн тохирох, амлалт өгөх, шан харамж авах, үйлчилгээ, зээл авах, ийнхүү авахаар шахаж шаардах, ятгах, бусдад зуучлах, хуульд харш болзол тавих, далайлган сүрдүүлэх, бусдын өмч хөрөнгийг хувийн болон албан ажилд ашиглахгүй байх;

2.3.6. төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус албаны шалгалт явуулахдаа ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй нөхцөлд албан үүргээ гүйцэтгэхээс татгалзаж, энэ тухай эрх бүхий байгууллага, албан тушаалтанд мэдэгдэх;

2.3.7. байгууллагын өмч хөрөнгө, техник хэрэгслийг албаны бус зориулалтаар ашиглах, үрэгдүүлэхгүй байх;

2.3.8. Дотоодын цэргийн командлагч, Дотоодын цэргийн штабын даргын зөвшөөрөлгүй төр засгийн шагналаар шагнуулахгүй байх.

2.4. Ёс суртахуунтай байх:

2.4.1. өөрийн болон албаны нэр төрийг ариун байлгах, иргэд, хамгаалуулагч байгууллагын ажилтан, алба хаагчтай соёлтой, хүнлэг, хүлээцтэй харьцах, үл тоох, шаардлагагүй баримт бичиг нэхэх, гаргасан гомдол, хүсэлтийн талаар маргахгүй байх;

2.4.2. ажлын байр, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах, ялгаварлан гадуурхах, эрхшээлдээ байлгах, басамжлан доромжлох, сүрдүүлэхгүй байх;

2.4.3. байгууллагын зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэх талаар төрийн байгууллагаас явуулж байгаа аливаа үйл ажиллагааг эсэргүүцсэн мэдээ, мэдээлэл тараахгүй байх, энэ төрлийн арга хэмжээг зохион байгуулж, оролцохгүй байх;

2.4.4. албан ажилд шаардлагатай мэдээллийг санаатай нуун дарагдуулах, буруу мэдээллээр хангах замаар удирдлагын шийдвэр гаргах үйл ажиллагаанд саад учруулахгүй байх;

2.4.5. мөрийтэй болон элдэв төрлийн тоглоом тоглох, дуу хөгжим чанга тавих, хоорондоо зүй бус харьцах, бусдыг ажиллахад саад хийх;

2.4.6. ажлын байранд, ажлын цагаар, албан үүрэг гүйцэтгэж явахдаа болон дүрэмт хувцастай согтууруулах ундаа, мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бодис хэрэглэх, хуулиар хориглосон газарт тамхи татахгүй байх;

2.4.7. олон нийтийн газар, авто зам, гудамж талбайд бие засах, эсхүл нус цэр, шүлс, тамхины иш, хог хаяхгүй байх;

2.4.8. замын хөдөлгөөний дүрмийг чанд баримталж, согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодохгүй байх;

2.4.9. гэр бүл, үр хүүхдэдээ халамж анхааралтай байж, ёс суртахууны нийтээр зөвшөөрөгдсөн хэм хэмжээг сахин биелүүлэх;

2.4.10. олон нийтийн цахим сүлжээ, мэдээллийн сувгуудад зөвшөөрөгдсөнөөс бусад тохиолдолд албаны мэдээ, мэдээлэл, цагдаагийн болон цэргийн дүрэмт хувцастай зураг, санал, сэтгэгдэл оруулахгүй, ажлын цагаар хувийн асуудлаар цахим сүлжээнд орохгүй байх;

2.4.11. дүрэмт хувцас, албаны үнэмлэх, тэмдэг, тусгай болон техник хэрэгслийг бусдад дамжуулах, хэрэглүүлэх, бусдад барьцаа болгон үлдээхгүй байх;

2.4.12. иргэдтэй маргалдах, хэл амаар доромжлох, зохисгүй үг хэллэг хэрэглэх, шивнэлдэх, инээлдэх, залхсан, эсвэл уцаарласан өнгөөр харьцах зэргээр зан харьцааны дутагдал гаргахыг цээрлэх;

2.4.13. удирдах албан тушаалтан бусадтай соёлтой, хүнлэг, хүлээцтэй харьцаж, алба хаагчийн хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах тохиолдолд тэдгээрт урьдчилан мэдэгдэх, оролцоог нь хангах;

2.4.14. амралт, чөлөө, томилолтоор яваа алба хаагч хүндэтгэх шалтгаанаар өөрийн анги, байгууллагад хугацаандаа очиж чадахгүйд хүрвэл саатсан шалтгааныг харьяалах анги, байгууллагын захирагч /дарга/-д нэн даруй мэдэгдэх;

2.4.15. анги, байгууллагын үйл ажиллагааг мушгин гуйвуулах, хамт олны эв нэгдлийг бутаргах, үндэслэлгүйгээр гүтгэх, нэр, хоч өгөхийг цээрлэх.

2.5. Өөрийгөө хөгжүүлэх:

2.5.1. дотоодын цэргийн алба хаагч, ажилтан нь өөрийн мэдлэг, ур чадвар, мэргэшлийн төвшингөө дээшлүүлэх нь насан туршийн үйл явц гэж ухамсарлан ойлгож, бүхий л боломж, бололцоог ашиглан өөрийгөө хөгжүүлж, өөрийн алдаа, дутагдлыг арилгахыг эрмэлзэх бөгөөд дээд шатны удирдах албан тушаалтан дэмжлэг үзүүлнэ;

2.5.2. офицер, ахлагч нар биеийн жингийн зохист харьцааг хадгалан, цэргийн дүрэмт хувцсыг дүрмийн дагуу цэвэр үзэмжтэй өмсөнө.

Гурав. Гэрээт болон хугацаат цэргийн алба хаагчийн
ёс зүйн хэм хэмжээ

3.1. Хуулиар хүлээсэн үүргээ ухамсарлан, үлгэр жишээчээр биелүүлж, хууль тогтоомж, Монгол Улсын цэргийн нийтлэг дүрмүүдэд заасан хэм хэмжээг сахин биелүүлэхээс гадна дараах ёс зүйн хэм хэмжээг дагаж мөрдөнө:

3.1.1. сахилга баттай байж, аливаа хэрэг зөрчлөөс өөрийгөө болон нөхрийгөө урьдчилан сэргийлэх, дутагдлыг нуун дарагдуулахгүй байх;

3.1.2. эелдэг зан харьцаатай байж, биеэ зөв авч явах, бусдад үлгэрлэл үзүүлэх;

3.1.3. бие бялдраа чийрэгжүүлж, хувийн болон нийтийн ариун цэвэр, эрүүл ахуйг сахих;

3.1.4. эд хөрөнгийг хайрлан хамгаалж, дүрэмт хувцсыг цэвэр, үзэмжтэй, дүрмийн дагуу өмсөж хэрэглэх;

3.1.5. зэвсэгтэй харьцах, байлдааны техник дээр ажиллах үед болон бусад тохиолдолд хөдөлмөр, хамгааллын аюулгүй ажиллагааны дүрэм, зааврыг чанд сахих;

3.1.6. чөлөөгөөр явах хугацаанд хүндэтгэх шалтгаанаар өөрийн анги, байгууллагад хугацаандаа очиж чадахгүйд хүрвэл саатсан шалтгааныг нэн даруй харьяалах анги, байгууллагын захирагч /дарга/-д мэдэгдэх.

Дөрөв. Хариуцлага

4.1. Дотоодын цэргийн алба хаагч, ажилтан ёс зүйн зөрчил гаргасан бол түүний эрхэлж байгаа албан тушаал, цол, ажилласан жилийг үл харгалзан шалгаж шийдвэрлэнэ.

4.2. Ёс зүйн зөрчил гаргасан алба хаагч, ажилтанд эрх бүхий албан тушаалтан “Төрийн албаны тухай хууль”, “Цэргийн сахилгын дүрэм”-д заасан сахилгын шийтгэлийн аль нэгийг тухайн зөрчлийн шинж байдал, түүнийг анх буюу давтан үйлдсэнийг харгалзан, дэс дараалан хэрэглэхгүйгээр оногдуулна.

4.3. Ёс зүйн хэм хэмжээг ноцтой зөрчсөн алба хаагч, ажилтанг Төрийн албаны тухай хуулийн холбогдох заалтыг баримтлан албанаас хална.

4.4. Ёс зүйн зөрчил гаргаж, сахилгын шийтгэл хүлээсэн алба хаагч, ажилтанг “Төрийн албаны тухай хууль”, “Цэргийн сахилгын дүрэм”-д заасныг баримтлан, сахилгын шийтгэлгүйд тооцно.

4.5. Дээд шатны, эсхүл шийтгэл оногдуулсан дарга /захирагч/ өөрөө сахилгын шийтгэлийг хүчингүйд тооцох эрхийг эдэлнэ. Сахилгын шийтгэл үндэслэлгүй нь тогтоосон тохиолдолд шийтгэлийг хүчингүйд болгоно.

4.6. Төрийн албаны тухай хуулинд заасан хугацаа өнгөрсөн бол албаны шалгалт явуулж, сахилгын шийтгэл оногдуулж болохгүй.

Тав. Бусад

5.1. Ёс зүйн зөрчил гаргасан, хэм хэмжээ зөрчсөн алба хаагч, ажилтанд Дотоодын цэргийн командлагч болон Дотоодын цэргийн штабын дарга, анги, тусгай салбарын захирагч нь шалгагчийн дүгнэлт, саналыг үндэслэн /тушаалаар/ шийтгэл оногдуулна.

5.2. Дотоодын цэргийн штабын албан тушаалтан, анги, байгууллагын захирагч, дарга, түүний орлогч, гэрээт болон хугацаат цэргийн алба хаагчийн гаргасан зөрчил нь Монгол Улсын хуульд заасан гэмт хэргийн шинжтэй бол Дотоодын цэргийн штабын даргын тушаалаар, анги, байгууллагад ажилладаг офицер, ахлагч, ажилтны гаргасан зөрчил нь Монгол Улсын хуульд заасан гэмт хэргийн шинжтэй бол тухайн анги, байгууллагын захирагч, даргын тушаалаар хууль хяналтын байгууллагад шилжүүлнэ.

5.3. Ёс зүйн дүрмийн хэрэгжилтэд Дотоодын цэргийн штаб, анги, байгууллагын дарга, захирагч нар өдөр тутам хяналт тавьж ажиллана.

5.4. Дотоодын цэргийн штаб, анги, байгууллагын дарга, захирагч нар энэхүү дүрмийг алба хаагч, ажилтанд танилцуулан гарын үсэг зуруулж, жилийн эцсийн гүйцэтгэлийн тайлангын үр дүнгээр үнэлэлт, дүгнэлт өгнө.

5.5. Ёс зүйн хувьд бусдад үлгэр дуурайлал үзүүлсэн, иргэд, байгууллагын талархал хүлээсэн алба хаагч, ажилтанг дараах байдлаар урамшуулж болно:

5.5.1. хамт олны өмнө сайшааж хувийн хэрэгт тэмдэглэх;

5.5.2. цалинг үр дүнгээр нэмэх /тэтгэмж, мөнгөн урамшуулал олгох/;

5.5.3. боловсрол мэдлэгээ дээшлүүлэх, сургалтад хамрагдах эрх олгох;

5.5.4. цалинтай амралт, сувилалд хамруулах;

5.5.5. цагдаа, дотоодын цэргийн байгууллагын болон салбарын шагналд шагнуулахаар тодорхойлох;

5.5.6. албан тушаал дэвшүүлэх саналыг дээд шатны байгууллага, эрх бүхий албан тушаалтанд уламжлах;

5.5.7. нийгмийн асуудлыг шийдвэрлэх чиглэлээр дэмжлэг, тусалцаа үзүүлэх.